

ХОРИО ЦЭЭРИЙГ ТЭРСЭЛБЭЛ...

С.Дулам¹

Хорио цээр (taboo, tabou) гэж юу вэ? Өрнө дэхиний хэлэнд “taboo, tabou, tabu” хэмээх үг хоёр зүйлийн утгатай байдаг. Нэг нь энэ үг анх үүсч гарсан эл соёлын тусгайлсан утга, нөгөөх нь аливаа хориг, цээр ёсыг илэрхийлсэн харьцуулсан, түгээмэл утга болно. Бидний бодлоор монгол хэлний хувьд бол хоёрдахь утга нь илүү хамаатай. Сүүлийн хоёр зуу гаруй жилийн туршид ийм л хоёрдмол утгатай явж иржээ. “Tabu” хэмээх үг 1777 онд ахмад Кукийн гуравдахь аяны дараагаар өрнө дэхиний хэлэнд анх гарч ирсэн билээ. Ахмад Кук Тонга арлын Тонгатабу овгийн ахлаач нар чухам эл табу хэмээгчийн улмаас болоод суух ч эрхгүй, юм идэх ч эрхгүй байхыг олж үзжээ. Хожим нь энэ нэр томъёо Тайити арал дээр полинейзчуудын дунд түгээмэл байдаг “*tapu*” гэсэн хэлбэрээр ихээхэн түгэн тархсныг илрүүлсэн билээ. Ийнхүү анх орж ирсэн цагаасаа хойш баларлаг шашин мөргөлийн судлалд бүрмөсөн нэвтрэхдээ хоёр үндсэн хэлбэртэй болсон байна. Эхнийх нь Океаны язгуур нийгэм, шашин соёл дахь “*tapu*”-г харьцуулан судлах, дараагийнх нь дэлхий дэхиний хорио цээрийн олон янзын тогтолцоог харьцуулан судлах хоёр болно [Dictionnaire de l’ethnologie 1991, 695].²

Эхний судалгаанд үнэт хувь нэмэр оруулсан сэтгэгч З.Фрейд бичихдээ: “Дотоод гэхээсээ илүү гадаад шалтгааны улмаас ийн харьцуулан судлахын үүднээс угсаатан судлаачдын бидэнд тодорхойлж өгснөөр амьтны аймагт нь өөр хаана ч эрээд олохгүй баларлаг ул мөр үлдэж хоцорсон хамгаас залуу тивийн нэгэн Австралийн баларлаг оршин суугчид буюу хамгийн зэрлэг, хамгийн эртний, хамгийн хөөрхийлөлтэй овгуудыг би судалгаандаа сонгон авч байна. Австралийн баларлаг оршин суугчид бол бие бодын болон хэлний хамаадлаараа тэдний ойр хөрш меланези, полинези, малайчуудын алинд ч хавирахгүй тусдаа угсаатан юм гэж үздэг. Эл оршин суугчид бол орон байшин, урц балгаан алиныг ч барьдаггүй, газар тариалдаггүй, гэрийн тэжээмэл гэхээр юм нохой ч үгүй, шавар ваарын урлал ч үгүй юм гэдэг. Тэд ямар ч хамаагүй, цохиж алсан амьтны махаар л хооллодог, газраас өвс ургамлын үндэс ухаж амь зуудаг тийм улс аж. Тэдэнд хаан, овгийн ахлаач гэхээр юмгүй, биед хүрсэн эрчүүд нь цуглаж нийтийн хэргээ шийдээд л явцгаадаг байна. Тэднээс дээд Эзэн тэнгэрийг шүтэх маягийн шашин суртахуун олно нэж горьдолтгүй л болов уу. Тивийн дотоодын суугааль овгууд нь ус дутагдахын эрхээр хэлэхийн аргагүй хүнд нөхцлийг туулж амьдрах хийгээд хажуу хөршийн бусад овгуудаас ч илүү баларлаг харилцаатай байдаг гэх. Эл хөөрхий нүцгэн махчдаас биднийхтэй ойролцуу эр эмийн ёс суртахуун ажиглаж олно гэж хүлээгээд нэмэргүй атал тэдний бэлгийн зөн билгийн дотор ер бус хатуу цээр хязгаар байдаг

¹ ШУ-ы доктор, профессор. МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

² Dictionnaire de l’ethnologie et de l’anthropologie. Publié sous la direction de Pierre Bonte, Michel Izard, Press Universitaires de France, 1991, 755 p. [Dictionnaire de l’ethnologie 1991]

байна. Тэх тусмаа цус нийлэх бэлгийн харьцаан дээр очихоор хамгийн ягшмал цээрийг тогтоожээ” [Freud 1972, 10]³ гэсэн байна. Фрейдийн энэ үгнээс эхний “*tapu*” бол маш эрт баларлаг цагийн соёлын хоцрол мөн болохыг ойлгож болно.

Бид монгол угсаатны эртний хорио цээрийн тогтолцоог дангаар нь болон харьцуулан судлах талаар төдийлөн их ажил хийсэнгүй. Угтаа хорио цээр бол монгол язгуур соёлын хувьд бэлгэдлийн адил чухал зүйл мөн билээ. Бид энэ удаа эртний монголчуудын дунд байсан нэгэн мартагдсан хорио цээрийг нөхөн сэргээх оролдлого хийлээ. Энэ нь ордосчуудын дунд уламжилсан “Гурван марлын” домгоос сэргээж болохоор байгаа юм.

Гурван марлын үүслийн тухай домог олонхидоо Тэнгэрийн замын үүслийн домогтой нэгэн орчилд багтаж байдаг бол харин энэ домгийн ордос хувилбар нь биеэ даасан дэлгэрэнгүй өгүүлэмжтэй байдаг. Энэ домгийг Бельгийн монголч эрдэмтэн А. Мостаэрт “Ордос аман зохиол” бүтээлдээ хэвлүүлжээ [Mostaert 1937, 34-37].⁴ Шаазгай алаг хаан мянган ав тавьж явж байгаад нэг өдөр ердөө хоёр бөднө барьж. Тэр хоёр бөднийг хоёр хүнд өгч: “энүүнийг та хоёр аваад нэг айлд аваачиж, шарж аваад ир” гэжээ. Тэр хоёр хүн тэр хоёр бөднийг аваад нэг айлд эчихүлээ (*nēge ālt’ i’tč’iḡḡulē*), тэр айлын нэг эхнэр байна, өөр хүн үгүй ээ. Тэр хоёр хүн бөднөө аваачаад тэр айлын эхнэрт хэлж: “бид энэ хоёр бөднийг танайд шарж болгож аваад явъяа” гэхүлээ, тэр эхнэр: “болнай, болнай! шарж аваад яву” гэж хэлж. Тэр хоёр хүн бөднөө зууханд шарж тавиад, тэр эхнэрийг харахулаа, тэр эхнэр нэг цаасан шувуу хайчлаад нисгэж (*t’ere eḡḡener nēge tč’āsū šiwū ḡā’tš’ilāt niskḡeDži wān*) байна. Тэр хоёр хүн түүний нь гайхаж байсаар удаж. Гэнэтхэн сайхи шарсан бөднөөн үзэхүлээ, түлэгдэж нүүрс болчихож. Тэр хоёр тэрүүнээн үзээд, гаслаад уйлж. Чийгэхлээ, тэр эхнэр тэр хоёр хүнээс сурж: “та хоёр юунд уйласиим” гэхүлээ, тэд хэлж: “бид болволаа Шаазгай алаг хааны мянган ав тавьсан хүн-еимаа. Өнөөдөр (*unDuir*) ердөө хоёр бөднө барьсан-маа. Одоо таны зууханд шарж түлж нүүрс болгочиж. Бид хоёр (хоёул) одоо хаанд эчиж хэлбэл, бид хоёулыг яг алах” чийгэж хэлээд бас уйлж. Тэр үгийг тэр эхнэр сонсоод: “та хоёул битгий (*bi’tš’ige*) уйл. Би танд нэг арга хийяа” гэж хэлээд гурилаар (*gulirār*) хоёр бөднө засаж, зуухандаа шарж болгоод тэр хоёр хүнд өгч. Тэр хоёр хүн тэр бөднийг аваад хаандаа аваачиж өгч. Хаан тэр хоёр бөднийг идээд барсангүй түшмэддээ (*DušmeDt’ēn*) өгч. Түшмэд нь бас идэж барсангүй, мянган ав тавьсан хүндээ өгч. Даяар цадтал (*DžaDt’al*) идээд бас барсангүй үлэж гэнээ. Маргааш нь (*margā’t’uni*) Шаазгай алаг хаан бас мянган аваа тавьж олон гөрөөс баривч, мөн урьд өдрийн тэр хоёр хүнийг дуудаж ирүүлээд бас хоёр бөднө өгч: “та хоёр энэ бөднийг шарж аваад ир” гэж хэлэхүлээ, тэр хоёр хүн хоёр бөднийг аваад мөн тэр айлд аваачиж шарж. Тэр өдөр сайн хичээж (*Ge’tč’ēDži*) түлсэнгүй шарж аваад ирж хаандаа өгч. Хаан тэр хоёр бөднийг идэж цадсангүй ээ. Цадсангүй болоход тэр хоёр хүнийг дуудаж ирүүлээд хэлж: “өчигдрийн (*tč’uḡuDuirī*) хоёр бөднийг даяар идээд бас үлсэн. Өнөөдрийн хоёр бөднийг би гагцаар идэж цадсангүй ээ. Энэ учрыг та хоёул надад хэл. Энүүнд лав учир байх уу!” гэж асуухулаа, тэр хоёул аргагүй үнэнээ хэлж: “Өчигдрийн хоёр бөднийг тэр айл дээр аваачиж шараад тавиад, тэр айлын эхнэр нэг цаасан шувуу хайчлаад нисгэж байхыг гайхаж байгаад сайх шарсан бөднөө мартаж түлчихлээ. Тэрүүндээ бид гасалж байхулаа,

³ Freud Sigmund. Totem et Tabu. Interprétation par la psychanalyse de la vie social des peuples primitifs, “Petite Bibliothèque Payot”, Paris, 1972, 185 p. [Freud 1972]

⁴ Mostaert A. Textes oraux Ordos. MS, Mono Ser No. I, Peiping 1937, 765 p. [Mostaert 1937]

тэр эхнэр хоёр гурил бөднө засаж шарж манд өглөө. Чигээд бид аваад ирэсиймаа. Өнөөдрийн энэ хоёр бөднийг бид хоёул хичээж байгаад түлсэнгүй болгож аваад ирлээ” гэж хэлэхүлээ, тэр хаан энэ үгийг сонсоод бодож: “лав нэг эрдэмтий (*erDemt'ī*) эхнэр байх-майн (*bāḥa-mān*)” гэж бодоод, тэр хоёрт хэлж: “та хоёр яв; тэр эхнэрт хэл: миний мянган авын хүн ба малын идэх будаа, өвс, бордоог бүр бэлэн хий. Би маргааш тэнд эчияй. Энэ үгийг та хоёул эчиж тэр эхнэрт хэлээд тэнд намайг хүлээж бай”. Мөн хааны үгийг тэр эхнэрт эчиж хэлэхүлээ, тэр эхнэр сонсоод хэдэн хүн хөлсөлж аваад, тулга тогоо бэлэн хийж, бас морин онгоц уяа бэлдэж гүйцээгээд, маргааш ирэхийг хүлээж байтар Шаазгай алаг хаан мянган авчинаа дагуулаад эчиж үзэхүлээ, хүний амь зуух тогоо тулга, хүнс бүр бэлэн байхыг үзээд, бас морин онгоц, уяа бүр бэлэн байна. Тэр хаан тэр эхнэрийн гэрт эчиж тэр эхнэрийг үзэхүлээ, нэг сайхан зүстэй эхнэр байна. Бас хэлэх үгийг соносхулаа, мэргэн эрдэмтий эхнэр байна.

Домгийн энэ өгүүлэмжид эн тэргүүнээ аливаа хориг цээрийг тэрсэлбэл дуусашгүй зовлон гамшиг, эмгэнэлд учирнаа гэсэн нэгэн далд санаа нуугджээ. Гэвч энэ далд санаагаа сайтар нууцалсан мэт байх тул илдээ огт мэдэгдэхгүй байна. Одоо ч гэсэн уншигч авгай та чухам ямархан хориг цээрийг давж тэрсэлсэн юм бол хэмээн бодож байгаа. Гэтэл энэ эхнэр эртний монголчуудын гэрт мах шарахыг хориглосон өвөрмөц нэгэн хорио цээрийг тэрсэлсэн байна. Угтаа Шаазгай алаг хааны зарлигийг дагасан буюу хээр хөдөө өлсч яваа хоёр хүнийг өрөвдөж энэрснээсээ болоод ангийн олз болох хоёр бөднө шувууны махыг шарж болгохыг зөвшөөрсөн юм шиг энд гарч байгаа. Бас монголчууд бөднө шувууг хэрүүлчийн ёгтолмол болгож, “бөднө шувуу мэт хэрүүлч” гэхчлэн хэлдэг тул хэрүүлч бөднийн⁵ махыг гэртээ шарсан нь нэрмээс болсон байхаа ядахгүй. Юутай ч гэсэн чухам энэ мах шарсанаас болоод өнөө хоёр гайхал нь нүүрс болтол түлчихсэн, түлснийг нь нөхөн төлж өгөхийн тул эхнэр хоёр гурилан бөднө шарж өгсөн, тэрүүний махыг хаан, түшмэд, мянган авын хүмүүстэйгээ идээд бараагүй, тэр нь хааныг гайхалд оруулж, “эрдэмтэй” эхнэрийг авахаар шийдсэн, эхнэрийг нь хатнаа болгохын тул эр нөхрийг нь ангаас ирэхэд тосч алах санаа агуулсан гэх мэтчилэн эцэс төгсгөлгүй өрнөж байна. Өнөө хүртэл зарим нутагт дагаж баримталсаар яваа нэгэн хорио цээр бол гэрт мах шарахыг цээрлэдэг буюу зочноо шарсан махаар дайлахыг цээрлэдэг ёс заншил болно. Энэ нь угтаа ан агнуурын цаг үеэс уламжилсан заншил бөгөөд зөвхөн анчин гөрөөчин, хээр гадаа яваа хүн агнасан ангийнхаа махыг шарж болгож иддэг, харин гэрт бол тэр махыг зөвхөн чанаж болгож иддэг хатуу ёс заншилтай байжээ. Учир нь хээр гадаа болохлоор шарсан махны үнэрээр хуран цуглаж хооллодог хий биетэй, хийсгэлэн дүртэй олон хий амьтан байдаг гэж үзэж төсөөлдөг бөгөөд тэднийг цатгаж тэжээснээрээ ангийн олз омог сайн болж, өлзий хийморьтой явдаг гэж үздэг. Гэтэл гэрт мах шарах юм бол өнөө олон үнэрээр хооллодог хий биетэй,

⁵ Бөднө шувууны бие махбод нь элдэв өвчинд нэн тэсвэртэй, дархлаатай болохыг хүн аль эртнээс олж мэджээ. Бөднийн өндгөнд биологийн идэвхит бодос байдаг тул түүхийгээр нь идэхэд айж эмээх зүйлгүй гэдэг. Японд бөднийн өндгийг бие махбод нөхөн сэргээх, бэлгийн чалхад сайн гэж үнэлдэг бол Солонгос, Хятадад бүр эрт дээр үеэс хаад ихэсийн бэлгийн чалх сайжруулахад хэрэглэдэг байсан аж. Нас ахисан хүмүүс бөднийн өндгийг хүнсэндээ тогтмол хэрэглэхэд хоёр сарын дараа үе мөчөөр нь өвдөхөө больж, үсний уг бэхжин, хараа сонсгол нь сайжирсан байдаг.

хийсгэлэн дүртэй амьтас нь гэрт орж ирэх учраас ямархан нэгэн муу юм дагуулдаг гэж үзэж төсөөлдөгтэй холбоотой. Хэрэв ийнхүү хиншүү гаргах учиртай болбол заавал гадаа тусгай индэр засаж шатаадгийг эргэн бодож үзүүштэй. Харин гэрт бол уг идээ шүүсийг заавал гал түлж, тулга тогоо угсарч, чанаж болгож иддэг учиртай. Энэ нь ан гөрөөний олз омгийн мах хүнслэх ёс бол “модон тогоонд”⁶ шарж болгох ёс, мал ахуйн идээ шүүсийг бол гэрт тулга тогоонд чанаж болгож идэх ёс гэсэн ийм хоёр тод ялгаатай зүйл байжээ. Бүтэц зүйн хүн судлалын онолч Клод Леви-Строссын онолоор бол монгол хоол хүнсний соёлд Шарсан-Чанасан гэсэн хосмолжин эсрэгцэл (*opposition binaire*) байсан бөгөөд энэ нь Ан гөрөө-Мал ахуй, Хээр гадаа-Гэрийн дотор гэсэн хосмолжин эсрэгцлийн төлөөлөл байжээ. Ер нь ан агнуурын ёс, мал ахуйн ёсонд ялгаатай зүйл элбэг байх бөгөөд мэндлэх мэндчилгээ нь хүртэл ондоо ондоон байна. Ангийн ёсонд ан агнаад хуулж буй хүнтэй таарвал “Сайн байна уу” гэж мэндэлдэггүй, “Билүүд” гэж мэндэлдэг, “Сайн байна уу гэж” мэндэлсэн хүнийг анчин урд хормойг нь огтолдог учиртай байна. Мөн иддэг хоол унд нь ч гэрийн хоолноос гойд ялгаатай ажгуу. Үүний нэгэн жишээ бол төв халхын анчин гөрөөчдийн хээр болгож иддэг “Хавсарга” хэмээх хоол юм. Нэг ургаа хавтгай хадан дээр өөр нэгэн хавтгай хадыг босгоод (салхины өөдөөс) хожуул овоолон галдаж гал түлээд хоёр хад нь улайсахлаар шүүрдэж цэвэрлээд том том хавтгай мах наалдуулж тавиад дээр нь давс сонгино асгаад мөн дахин том далбагар махнуудыг давхарлаж тавьсаар хэдэн давхар болмогц нь нөгөө босгосон хавтгай хадаа аяархан дээр нь хөмрөөд тавьчихна. Тэгээд хэсэг хугацаа өнгөрсний дараа маш сайхан амттай, хавтгай хавтгай, шар шар мах болно. Тэр хавийн газар ч гэсэн шарсан махны үнэрээр ханана. Үүнийг “Хавсарга” гэж нэрлэдэг.⁷ Монгол тайлга тахилгын соёлд ч гэсэн энэхүү хиншүү гаргах ёсыг дутагдаж болшгүй зүйл хэмээн үзэж, бөө мөргөлийн хээрийн тайлга тахилга зэрэгт чунсал өргөх, доён шатаах ёс үйлддэг билээ. “Чунсал өргөх” гэдэг нь тайлга тахилгын үеэр нарийн модыг цуулж дөрвөлжлөн өрөөд галд нь богино хавирга, өвчүүний бүдэрхий, шагайт чөмөг, халцгай хавирга, уураг сүүлний өөх гэсэн таван жижиг махыг өргөж, хиншүүний үнэр гарган муусайн юмдыг хооллохыг хэлдэг [Дулам 1992, 22].⁸ Эндээс үзвэл ан агнуурын соёл, мал ахуйн соёл хоёр нь анхандаа тун гойд ялгаатай байж, мэндчилдэг мэндчилгээ, иддэг хоол хүнс, ёс заншил, хорио цээр нь хүртэл ондоо ондоо байсан аж.

Ордосчуудын “Гурван марал” домогт цааш нь өгүүлэхдээ: “Энүүнийг мэдээд тэр эхнэрийг хатнаа (ga‘t‘unāā) болгож авах санаа төрж. Тэр эхнэрээс сурж: “чиний гэрийн эзэн хэн гэдийм? Хаана явуваа” гэж сурахлаа, тэр эхнэр хэлж: “миний эрийн нэр болволаа Ажиндай мэргэн гэж нэртэй; гурван сарын газарт ав хийхээр явусаан! Одоо

⁶ Модыг шорлон үзүүрлэж, агнасан ангийнхаа махыг шарж идэхийг монгол үлгэр, домогт ингэж хэлдэг. “Цэцэн бэрийн үлгэрт” аав нь цаашаа явж, нэгэн гөрөөс алж түүнийгээ янзалж байгаад “миний хүү гал түлээд аавынхаа модон тогоог тулах хэрэгтэй” гэж хэлсэнд хүү нь гал түлж, бүдүүн мод унагаж, бөгсийг тайрч ухаж байж гэнэ. Хаан хүүгээсээ “миний хүү юу хийж байна” гэсэнд “би модон тогоо ухаж байна” гэж гэнэ. “Үүнийг модон тогоо гэдэг юмуу” гээд хүүгээ зодож гэнэ” [МАУ 1982, 209-210] гэхчлэн гардаг билээ.

⁶ 2003 оны 8-р сарын 3-нд Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Баянбүрд багийн малчин, 71 настай Бадарчийн Батсүх гуайгаас тэмдэглэн авав.

⁷ Дулам С. Дархад бөөгийн уламжлал. Латин галиг, удиртгал тайлбартай, Эрхэлсэн О.Пүрэв, МУИС-ийн хэвлэл, Улаанбаатар, 1992, 200 т. х. [Дулам 1992]

харьж ирэхдээ шахсаан!” гэж хэлэхлээ, тэр хаан тэр үгийг сонсоод, тэр ойр орчин ав хийж, Ажиндай мэргэнийг амдаж байгаад, тэрүүнийг барьж алах санаа төрж. Чийгээд байтал удсангүй Ажиндай мэргэн харьж ирэх замд Шаазгай алаг хаан тэрүүнийг барьж аваад алах гэхлээ, Ажиндай мэргэн хэлж: “чи намайг ямар учирын төлөө алаха-мий?” [35] гэж асуухлаа, тэр хаан хэлж: “би чамайг алаад эхнэрийг би авууяа” гэж хэлэхлээ, Ажиндай мэргэн хэлж: “чийм болвол чи намайг алж хэрэггүй ээ. Намайг нэг авдранд савлаад, хадаад, бас нэг авдранд хад хийж тэнцээгээд, миний моринд ачаад тавьчих! Миний морь намайг аваад миний авладаг газарт явухуу! Би тэр авдран дотор үхэл-үгүүдоо” гэж хэлэхлээ, тэр хаан тэрүүн үгээр авдранд савлаж хадаад, бас нэг авдранд чулуу тэнцээгээд, моринд нь ачаад тавьчихлаа, мөн авладаг тэр газар луу тэр морь явчихлаа. Тэрүүний авч явсан нэг тэмээ, хоёр нохой бас тэр морийг дагаад явчихлаа.

Энэ өгүүлэмжээс үзвэл, хүн зоны аж зуулга нь ан гөрөөгөөр голдсон цаг үе мэдэгдэж байна. Хаан нь мянган авчнаа дагуулан ав хоморго хийж яваа дүр зураг, харьяат албат нь бас олон сарын газар ан гөрөөнд явдаг ийм байдалтай аж. Бидний бодлоор энэ бол анчин-түүн цуглуулагчдын цаг үеэс мал ахуйн соёлд шилжиж байх зааг үеийг тусгасан шинжтэй байна. Овог аймгийн хам олон ан гөрөөний олз омгоор аж төрж байсан цаг үе байгаль, нийгмийн элдэв учир шалтгаанаас болоод хоол хүнсний хомсдолд орж, хүнсний өөр шинэ эх үүсвэр эрж олох шаардлага тулгарч байгааг энэ домогт тодорхой сайхан өгүүлж байна. Энэ шинэ эх үүсвэр нь манай малчин-нүүдэлчин өвөг дээдсийн ухаалан бодож, олж нээснээр бол нүүдлийн, бэлчээрийн мал ахуйн соёл байлаа. Ийм барагдашгүй хоол хүнсний эх үүсвэртэй болохын мөрөөдөл нь Ажиндай мэргэний эхнэрийн гурилаар хийсэн хоёр бөднийн махыг хаан, түшмэд, мянган авчинтайгаа идээд барахгүй байгаагаар, мянган авын хүн ба малын идэх будаа, өвс, бордоог бэлэн болгож, хүний амь зуух тогоо тулга хүнс, морины онгоц уяаг ид шидээр бэлэн болгож байгаагаар илтгэсэн байна. Энэ хомсдолын улмаас “мянган хүн хоёр бөднийн махаар хооллох” хэрэгцээ ч гардаг байсан цаг аж. Хоол хүнсний энэ хомсдолын тухайд домгийн төгсгөлд илүү яруу тодорхой өгүүлэх бөгөөд Шаазгай алаг хаан Ажиндай мэргэнийг хөөж, гурван сарын газарт нь хүрэхийн тул өлбөрөх, үхэх, тагдахдаа тулж хэдхэн хүн амьд үлдсэн гэж өгүүлж байна. Чухам ав хоморгоор аж төрөхөд хүйтэн цаг улиралд нь мах шүүсээ хадгалахад санаа түвдэх юмгүй боловч халуун дулааны улиралд хөргөх хадгалах газаргүйн харгайгаар ихээр нөөцлөх боломжгүй, эсвэл зарим үед ангийн ганзага, олз омог аанай болж, хоёрхон шувууны махтай үлдэх зэрэг учир тохиол олон гардагийн улмаас хүнсний бэлэн нөөцөө хэзээ ч үл муудах амьд байдлаар адгуулан хадгалж, ойр дэргэдээ байлгахын тул зэрлэг амьтдын үр төлийг барьж гаршуулан тэжээх, ядарч доройтсон нэгнийг сувиалан тэнхрүүлж гэршүүлэн өөрийн болгох, зэрлэг догшиныг номхотгох зэрэг олон аргаар “мал малын захтай” болж эхэлсэн цаг санж. Чухам энэ байдлыг үзүүлэхийн тул Ажиндай мэргэн ажин хул морьтой, ганц тэмээтэй, хоёр нохойтой байгаагаар тэд нь эзэндээ туйлын үнэнч байгаагаар дүрсэлсэн болно.

Ордос домгийн өгүүлэмжийг цааш нь сонирхон үзвэл “тэрүүн[ий] хойтой тэр хаан Ажиндай мэргэний гэрт ирж эхнэрт нь энэ явдлыг бүр хэлж. “Одоо би чамайг эхнэрээн хийж авуяа” гэж хэлэхүлээ тэр эхнэр аргагүй эхнэр нь болж. Эхнэр нь боловч гэдсэнд нь (*geDusunDuni*) гурван сартай хүүхэд байж. Тэрүүн[ий] хойтой долоон сар болоход нэг хүү төрж. Хүү төрснөөс хойшоо арван жил болж. Тэр хүү арван настай болж. Хүн болгон тэр хүүгий Ажиндай мэргэний хүү гэж хэлээд байхулаа, энэ үгийг олон сонсоод

эхээсээ сурсан маань: “би Шаазгай алаг хааны хүү байтар, намайг хүн болгон Ажиндай мэргэний хүү гэж хэлээд байхам. Мээмүү чи надад энэ үгийг бүр хэлээ!” гэж эхийгээ дахин дахин шахаад байхулаа, эх нь аргагүй хүүдээ хэлж: “чи чухам (Džuxum) Ажиндай мэргэний хүү мөөн” гэж хэлэхүлээ, хүү нь эхээсээ сурж: “би Ажиндай мэргэний хүү мөн болуун, миний эцэг хайш явус-им” гэж асуухлаа, эх нь хэлж: “Шаазгай алаг хаан эцгий чинь барьж аваад, авдранд савлаж хадаад, ажин хул моринд нь ачаад туучихсаан! Морь нь яваад авладаг газартаан хүрсээн! (Guursēn)” гэж хэлэхүлээ, тэр хүү эхдээ хэлж: “над унаа хүнс өг. Би эцгийнээн хойноос эчинээ” гэж хэлэхүлээ, эх нь хорьж: “чи эчиж хэрэггүй ээ. Эцэг чинь хэзээ-үгүй үхчихсэн мэлээ! (mēlē). Чи эчиеэ тус үгүй ээ! (Dusa-ugē)” гэж хорьж. Хоривочи хүү нь болсонгүй явах болж. Эх нь Шаазгай алаг хаанаас нууж унаа хүнс төхөөрч (Dóħkħóórtš‘i) өгч. Хүүгээн хэлж: “Чи Шаазгай алаг хаанд мэдэгдэж болохгүй ээ. Мэдвэл чамайг алахуу. Чи хүнд мэдэгдэхгүйгээр нууж яву. Чиний эцэг гурван сарын газарт Ар хангай гэж нэртэй газарт авлад-имаа. Тэр газрыг сураглаад явуу!”. Эхийнээн (eħkħīnēn) энэ үгийг сонсоод, хүү нь унаа хүнсээн аваад явж гэнээ.

Эндээс ажиглаж болох нэг үлэмж сонирхолтой зүйл бол анчин эрийн анд унадаг морь нь эзнийхээ авладаг газар хар аяндаа хүрч очдог ая зантай байгаа нь болно. Учир нь энэ морь бол чухамдаа дөнгөж саяхан агнадаг ан гөрөөнийх нь нэгэн байсан тул заримдаг (хагас) зэрлэг, заримдаг гэрийн амьтан мөн бөгөөд Ажиндай мэргэн түүгээр бусад ан, адуун гөрөөсийг эндүүрүүлж гөрөөлдөг тийм морь байсан аж. Тийм болохоор энэ морь жолоо цулбуурыг сул орхивол буцаад анхны ижил сүрэгтээ ирж нийлдэг гэсэн үг. Нөгөөтэйгүүр, морины нэрийг “ажин хул” гээд байгаа нь “аж зуулгын унаа” гэсэн санаа байхаас гадна “хул” зүстэй байгаа нь хулан мэт зэрлэг адуун гөрөөсний зүс зүсэм болно. Бас Ажиндай мэргэний “авладаг газар” гэдэг нь үнэндээ бүтэн болон хагас зэрлэг ан амьтдын байдаг газар нь тэдний бүтэн зэрлэг амьтдыг нь агнаж, өөртөө дасгасан хагас зэрлэг амьтдыг нь адгуулдаг ийм хүн байжээ. Харин бүрэн гаршиж өөрийн болсон нь мөнхүү нэг морь, нэг тэмээ, хоёр нохой болно.

Домог цааш үргэлжлэхдээ “тэр хэрдээн (k‘erDēē) яваад, гурван сар болоход, эцгийнээн (e‘tš‘igīnēn) авладаг газарт гүрч. Тэр газарт эрэхүлээ олдогүй ээ. Мэлээд (mēlē) хэдэн өдөр эрж байтал, нэг өдөр нэг моринд авдар ачсан, нэг тэмээ, хоёр нохой хэдүүл байсныг үзээд ойртоод эчихүлээ, хоёр нохой нь хоргоогоод (ħurāgāt) ердөөн ойртуулахгүй ээ. Тэр хоёр нохойд аргагүй болоход эргэж бэлчээрээс нэг хоёр гөрөөс алж аваад, махаар нь тэр хоёр нохойг хуурч. Арайхан хоргоохгүй болж байтар, бас дэргэд нь эчье гэхүлээ, тэр тэмээ ердөөн ойртуулахгүй ээ. Ойртуулахгүй болохулаа, өвс түүж шидээд (tš‘iDēDži) аажмаар дасгаж, тэр тэмээ харуулгүй болж. Дэргэд нь хүрхүлээ, тэр морь цавчихтай өшгөлөхтэй (ōsk‘ōlkħu‘t‘i) ер ойртуулахгүй. Бас өвс түүж шидээд жаахан аярахулаа, шидсээр морь бас гэмгүй болж. Биенд нь гар хүрч (guirtš‘i) тэр авдрыг буулгаж хадсан хадаасыг сугалж (DzugalDži) нэгий нь нээхүлээ, дотор нь хад байна. Бас нэг авдары нь хагзалж (ħagDžalDži) үзэхүлээ, нэг үхсэн хүн байхыг үзээд, авдарнаас гаргахулаа, амьд байх маягтайгий нь үзээд, хурдан нэг бөднө харваж аваад, тэрүүнийг чанаад, шөлий нь эцгийнээн аманд жаахан жаахан цутгаж (DžuDħuDži) байтал, амихаж байх маяг мэдэгдэж. Бас явж хэдэн бөднө харваж аваад ирж чанаад, бас шөлий нь цутгаж байтар, эцэг нь нүдээ харж үг хэлж: “чи хэн гэгч байна?” гэж асуухулаа: “би чухам Ажиндай мэргэн гээчийн хүү байна” гэж хэлэхүлээ, Ажиндай мэргэн хэлж: “миний чухам хүү байхгүй ээ. чи над нарийн хэл” гэж асуухулаа, хүү нь

хэлж: “Шаазгай алаг хаан чамайг авдранд хийж хадаад, ажин хул моринд чинь ачаад, авладаг Ар хангай газарт чинь явуулчихсаныг би мээмээсээн (*mēmēsē*) сонсоод асуухулаа, тэр үест би хэвлийн дотор гурван сартай байсныг надад хэлж өгсөн. Энэ үгийг сонсоод, чи миний эцэг байхыг би мэдээд, чиний хойноос одоо хөөж ирсэн-маа”. Энэ үгийг эцэг нь сонсоод хэлж: “зай! Би мэдлээ. Би өлсч байнаа” гэж хэлхээлээ, хүү нь хурдан бөднөөн махыг өгч идүүлээд, тэндээрээс эцэг хүү хоёул танилцаж”.

Энэ хэсэгт амьтныг хэрхэн биедээ дасгаж өөрийншүүлдэг арга барилыг өгүүлсэн байх агаад үүнд маханд дуртайд нь мах хаяж өгч, өвсөнд дуртайд нь өвс шидэж өгсөөр “аяруулдаг” байсан аж. Бас Ажиндай мэргэний хүү эцгээ эрж алс холоос тэмцэн ирсэн учир бол нэгэн овог аймгийн дотор өөр мах цусны хүн байж болдоггүйтэй холбоотой гэмээр бөгөөд чухам иймээс төрсөн эцгээ дагаж бараадаж ирэх нь илүү чухал гэсэн үг.

Ордос домгийн төгсгөлд “хүү нь эцгийгээн сайхан асарч мэлүү (нэлээн) хэдэн сар болж. Хүү нь эцэгтээн хэлж: “аав одоо гэмгүй болжий! Чи бида хоёул одоо харьцгааяа!” гэж хэлэхүлээ, эцэг нь хэлж: “Чи бида хоёул одоо харьж болохгүй ээ. Чи бида хоёул одоо харивал Шаазгай алаг хаан чи бида хоёулыг барьж алахуу!”. Чигэж хэлээд эцэг нь явахгүй ээ. Хүү нь эхийгээ санаад харих санаатай болвочи, эцэг нь харихгүй болхулаа, тэнд хоёул авлаж нэг жил болж байтар, эх нь хүүгээн санаж тэсэхгүй (*Desk'ni*) болоход яварын санаа төрж. Шаазгай алаг хаан мянган ав тавьж авлахаар явсан хойно, тэр эхнэр хүнс төхөөрч аваад, нэг сайн морь сунгаж унаад, хүүгийнээн хойноос босч явж. Гурван сар яваад мөн тэр газар хүрч. Эр хүү хоёрыгаан эрж олж золгоод, гурвуулаа нийлж хэдэн өдөр болсон хойтой Ажиндай мэргэн хэлж: “эхнэр чи, эргэж хурдан харь. Чи эс харьвал Шаазгай алаг хаан чамайг хөөж ирэхүү! Хөөж ирээд чи бида хэдүүлийг барьж авбал (*abbal*), лав бида хоёулыг алах. Тэрүүнээн оронд чи харьсан дээр” гэж хэлэхүлээ, хэлж: “энэ хэдэн сарын газар хол байнаа: хөөж ирэхгүй ээ” гэж хэлээд сууж хэдэн сар болжойтор (болжи вайтар), Шаазгай алаг хаан энэ эхнэр дутаагаад явсаныг мэдээд, төдүй (*t'uDui*) хойноосон мянган авчнаан дагуулаад хөөж хэдэн сар яваад, тэр газар гүртэр дагуулсан олон авчин нь идэх уух юм олдоггүй, өлбөрөхтэй (*ōlbōrkxō't'i*), үхэхтэй (*шхкхшхкхш't'i*), тагдахтай (*t'aGDaxu't'ā*) тэр газар хүрэхэд хэдүхэн хүн үлигдэж. Тэр гурвуулыг олж бараа бараагаан үзэлцэж. Ажиндай мэргэн үзсэн хэрдээ дутааж. Хүү нь эцгийнээн хойноос хөөж. Эх нь хүүгийнээн хойноос хөөж. Гурвуул дагалцаад нэгэн нэгийгээн хөөлөлцөөд явсаныг Шаазгай алаг хаан үзээд, байсан цэргээ (*tširigēē*) дагуулаад хойноосон хөөж. Хөөсөөр хөөсөөр тэр гурвуул тэнгэрлүү гараад явчихаж. Тэндээр Шаазгай алаг хаан аргагүй тагдаж гэнээ. Тэр гурвуул хөөлөлцсөөр тэнгэрт гараад, одоо болтор хөөлөлцсөөр байна. Гурван марал гэгч тэр гэнээ [Mostaert 1937, 34-37].

Ажиндай мэргэн, түүний “эрдэмтэй” эхнэр хоёр бол ан агнуурын соёлыг мал ахуйн соёл болгон хувиргахад онцгой үүрэг гүйцэтгэсэн хос соёлт баатрын шинжтэй байгаа билээ. Энэ хоёр нэг нь ан гөрөөг мал ахуй болгон хувиргагч бол нөгөө нь тэр мал амьтны биеэс эд баялаг, хүнс хоол (тулга тогоо, морины онгоц мэтийн тусламжтай) гаргаж, арвижуулан бүтээгч мөн болно. Харин Шаазгай алаг хаан бол идэш тэжээл олох ганцаас өөр эрдэм аргагүй, хүмүүний бэлэн болгосон бүтээл туурвилыг завшин аж төрөгч бөгөөд зөвхөн олон авчиныхаа сүр бараагаар бусдын баялагийг булаан дээрэмдэгч болно. Түүний хүнсний хомсдлоос гарах гол арга нь ийм хоол хүнсний барагдашгүй эх сурвалж болсон үйлч бүтээлч нэгнийг

биедээ эзэрхэн дарангуйлж байх явдал юм (“миний мянган авын хүн ба малын идэх будаа, өвс, бордоог бүр бэлэн хий” гэхчлэн тушаах жишээтэй). Тиймээс ч баялаг бүтээгч гэсэн утгаар Ажиндай мэргэний эхнэрийг “лав нэг эрдэмтий эхнэр байх-майн” гэж хэлж байна. Чухам энэ учраар бэлэн тэжээгчээ алдахгүйн төлөөнөөс Шаазгай алаг хаан олон сарын хол газар, мянган авчнаа өлбөрүүлэн байж араас нь нэхэж ирсэн байна. Тэхлээр энэ домгийн гол санаа нь үйлч бүтээлч, авьяас билигтэн, тийм эрдэм чадалгүй, эрх хүчнээр эрэлхэн эзэрхэгч хоёрын тэмцэл юм. Энд нэг зүйлийг сануулахад Долоон бурхан одны тухай ордос домгийн ах дүү долоон ид чадалтан баатрууд нийлээд зүүн хойд зүгт, гадаад далайн цаадтай байх Шаазгай хаан гэгчийг дарахаар явцгааж байдаг нь ийм үйл бүтээлийн эзэд нэгдэн нийлээд бүтээл туувил бусниулагчийг хүчээр үгүй хийдэг байсан гэсэн үг. Гэтэл энэ домогт Ажиндай мэргэн эхнэр хүүхдээс өөр хавсрах хүчингүйн улмаас хайртай хүмүүсээ авч, тэнгэрт дэвшин оргож зугадахаас өөр арга байсангүй. Ажиндай мэргэн хавсрах хүчингүйн мөхөсдлөө “Хүү нь эцэгтээн хэлж: “аав одоо гэмгүй болжий! Чи бида хоёул одоо харьцгаая!” гэж хэлэхүлээ, эцэг нь хэлж: “Чи бида хоёул одоо харьж болохгүй ээ. Чи бида хоёул одоо харивал Шаазгай алаг хаан чи бида хоёулыг барьж алахуу!”. Чигэж хэлээд эцэг нь явахгүй” байгаагаар ч юмуу, “эхнэр чи, эргэж хурдан харь. Чи эс харьвал Шаазгай алаг хаан чамайг хөөж ирэхүү! Хөөж ирээд чи бида хэдүүлийг барьж авбал, лав бида хоёулыг алах. Тэрүүнээн оронд чи харьсан дээр” гэхчлэн хэлж байгаагаас тодорхой байна. Өөрөөр хэлбэл, өөрөө юу ч хийж бүтээж үл чадахын учраар үйлч бүтээлч нэгнийг гэр бүлээс нь хагацуулан булааж, бусдыг нь алж хөнөөх бөгөөд харин өөрөө бэлэн зүйл дээр амьдрахын тул баялаг бүтээгчээ арай алж дөнгөхгүй гэсэн үг. Ийнхүү гэрийн дотор мах шарах хорио цээрийг тэрсэлсний улмаас нэгэн үйлч бүтээлч өрх айл салж сарниж, амь нас сүйдэхдээ тулж, амьдын хагацал зовлон хаа хаанаа амсч явж сая ертөнцийн ондоон нэгэн орон зайд эвлэн бүтсэн боловч цагийн цагт нэг нэгнээ хөөцөлдөн байх үйлэнд учирч, энэ учир ёсыг олноо сэнхрүүлж байхын тул тэнгэрт тэмдэгтэй од болгон мөнхөлсөн ажгуу. Чингэхдээ бас л энэхүү Гурван марал одны домгийн гол баатар нь Хөхдэй мэргэний нэгэн адил харваач мэргэн байдаг гол шугамаа алдахгүй байна.

Энэ домгийн утга санааны алсын тусгал нь аливаа нийгмийн дотор эд баялагийг бүтээгч, түүнийг завшин амьдрагч хоёр янзын хүн байдаг бөгөөд нэгэн удам угсааны дотор ч гэсэн хийж бүтээдэг нэгэн хоёр нь залгин завшигч бусад олныгоо үүрч чирч явдаг, нэгэн гэрийн дотор ч гэсэн тэжээгч, тэжээлгэгч хоёр янзын хүн байдгийг зөнч мэргэн онож үзүүлсэн нь үлэмж орчин үеийн утга санаатай гэж болно.

Зүүлтийн ном зүй

1. Дулам С. Дархад бөөгийн уламжлал. Латин галиг, удиртгал тайлбартай, Эрхэлсэн О.Пүрэв, МУИС-ийн хэвлэл, Улаанбаатар, 1992, 200 т. х.
2. Монгол ардын үлгэр (МАҮ). «Монгол ардын аман зохиолын чуулган», I боть. Д.Цэрэнсодном эмхтгэж, удиртгал, тайлбар бичив. Улсын хэвлэлийн газар, Улаанбаатар, 1982, 343 т. х.
3. Dictionnaire de l'ethnologie et de l'anthropologie. Publiй sous la direction de Pierre Bonte, Michel Izard, Press Universitaires de France, 1991, 755 p.
4. Freud Sigmund. Totem et Tabu. Interpretation par la psychanalyse de la vie social des peuples primitifs, "Petite Bibliothique Payot", Paris, 1972, 185 p.
5. Mostaert A. Textes oraux Ordos. MS, Mono Ser No. I, Peiping 1937, 765 p.

SUMMARY

Like symbolism taboo plays an important role in the Mongolian culture. In this paper, the author explains one forgotten taboo used by the ancient Mongols. This can be restored from the myth "Gurvan maral" which was traditionally spread among Ordos people.